



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ᠰᠣᠩᠭᠢᠨᠬᠠᠶᠢᠷᠬᠠᠨ
ᠳᠦᠦᠷᠭᠢᠨ
ᠵᠢᠰᠠᠭ
ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠳᠡᠷᠭᠡᠳᠡᠬᠡ
ᠰᠤᠲᠠᠳᠢᠰᠲᠢᠬᠢᠶᠢᠨ
ᠬᠡᠯᠲᠡᠰ

НИЙСЛЭЛИЙН
СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
АЮУЛГҮЙ БАЙДАЛ
2021 ОНД

Улаанбаатар хот 2022 он

Сонгинохайрхан дүүрэгт 2021 онд 94132 өрхийн 335703 хүн ам оршин сууж байсан бөгөөд дүүргийн хэмжээнд 2903 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 566(24.2%) хэргээр өссөн байна.Тайлант хугацаанд гарсан нийт гэмт хэргийн 2411(83.1%) нь хөнгөн, 492(16.9%) нь хүнд гэмт хэрэг байна. Тайлант онд гарсан гэмт хэргийн 360(12.4%) нь согтуугаар үйлдэгдсэн, 71(2.4%) нь хүүхэд оролцсон, 298(10.3%) нь эмэгтэйчүүд оролцсон, 215(7.4%) нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн байна.

Хүснэгт 1.Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо

Үзүүлэлт	Он	Бүх хэрэг	Гэмт хэргийн ангилал		Согтуугаар үйлдэгдсэн	Хүүхэд оролцсон	Эмэгтэйчүүд оролцсон	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас
			хөнгөн	хүнд				
Сонгинохайрхан	2020	2337	1787	550	321	110	289	116
I хэлтэс		1144	841	303	83	48	109	32
II хэлтэс		614	448	166	116	39	94	29
III хэлтэс		579	498	81	122	23	86	55
Сонгинохайрхан	2021	2903	2411	492	360	71	298	215
I хэлтэс		1469	1210	259	111	31	138	103
II хэлтэс		810	660	150	190	22	100	67
III хэлтэс		624	541	83	59	18	60	45
2021/2020		124.2	134.9	89.5	112.1	64.5	103.1	185.3


2021 онд Сонгинохайрхан дүүрэгт гарсан хэргийн 1469(50.6%) нь цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 810(27.9%)нь цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 624(21.5%) нь цагдаагийн гуравдугаар хэлтэст тус тус харьяалагдаж байна.

Хүснэгт 2.Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, дүүргээр

Дүүрэг	Бүх хэрэг			Гэмт хэргийн ангилал					
				Хөнгөн			Хүнд		
	2020	2021	еөрчлөлт	2020	2021	еөрчлөлт	2020	2021	еөрчлөлт
Нийслэл	14633	16534	113.0	12572	14763	117.4	2061	1771	85.9
Баянгол	2257	2758	122.2	2123	2608	122.8	134	150	111.9
Баянзүрх	4083	4217	103.3	3540	3737	105.6	543	480	88.4
Сүхбаатар	2023	2285	113.0	1764	2058	116.7	259	227	87.6
Сонгинохайрхан	2337	2903	124.2	1787	2411	134.9	550	492	89.5
Хан-уул	1650	2045	123.9	1431	1431	100.0	219	184	84.0
Чингэлтэй	1775	1864	105.0	1486	1682	113.2	289	182	63.0
Багануур	143	163	114.0	121	147	121.5	22	16	72.7
Багахангай	26	20	76.9	23	18	78.3	3	2	66.7
Налайх	339	279	82.3	297	241	81.1	42	38	90.5

2021 онд нийслэл хотод 16534 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 1910(13.0%) хэргээр буурсан байна. Нийт гарсан хэргийн 2758(16.7%) нь Баянгол, 4217(25.5%)нь Баянзүрх, 2285(13.8%) нь Сүхбаатар, 2903(17.6%)нь Сонгинохайрхан, 2045(12.4%)нь Хан-уул, 1864(11.3%) нь Чингэлтэй, 163(1.0%) нь Багануур, 20(0.1%) нь Багахангай, 279(1.7%) нь Налайх дүүрэгт тус тус гарсан байна. Тайлант онд нийслэл хотод гарсан нийт хэргийн 14763(89.3%) нь хөнгөн 1771(10.7%) хүнд гэмт хэрэг байсан байна.

Дүрслэл 1. Гэмт хэргийн тоо, дүүргээр



Хүснэгт 3. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, хэргийн ангиллаар

Үзүүлэлт	Он	хүний амьд явах эрхийн эсрэг			хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг			хүний бэлгийг эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг		хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг	
		Хүнийг алах	хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол	гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	хүчиндэх	Заналхийлэх			
Сонгинохайрхан	2020	47	17	794	711	8	59	53	7	1	
I хэлтэс		24	11	375	342	4	29	26	4	1	
II хэлтэс		14	4	211	175	4	23	22	1	0	
III хэлтэс		9	2	208	194	0	7	5	2	0	
Сонгинохайрхан	2021	49	20	1053	919	14	67	60	12	0	
I хэлтэс		21	7	523	453	8	38	35	10	0	
II хэлтэс		15	7	314	280	3	18	17	1	0	
III хэлтэс		13	6	216	186	3	11	8	1	0	
2021/2020		104.3	117.6	132.6	129.3	175.0	113.6	113.2	171.4	0.0	


Тайлант онд Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн нийт хэргийн 49(1.7%) нь хүний амьд явах эрхийн эсрэг, 1053(36.3%) нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 67(2.3%) нь хүний бэлгийг эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг, 12(0.4%) нь хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг, 30(1.0%) нь эдийн засгийн, 64(2.2%) нь олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхолын эсрэг, 2(0.1%) нь хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг, 6(0.2%) нь нийтийн албаны ашиг сонирхолын эсрэг, 17(0.6%) нь хүрээлэн байгаа байгаль орчны эсрэг, 10(0.3%) нь цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг, 4(0.1%) нь хүүхдийн эсрэг, 109(0.3%) нь хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслэлийн ашиглалтын журмын эсрэг хэргүүд байна.

Хүснэгт 3- ийн үргэлжлэл

Үзүүлэлт	Он	Эрүүл мэндийн эсрэг	Эдийн засгийн	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхолын эсрэг	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг	Нийтийн албаны ашиг сонирхолын эсрэг	Хүрээлэн байгаа байгаль орчны эсрэг	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэглэлийн ашиглалтын журмын эсрэг	Хүүхдийн эсрэг	Авлигын эсрэг
Сонгинохайрхан	2020	1	6	26	5	7	13	4	104	2	3
I хэлтэс		1	4	14	2	2	9	2	62	2	2
II хэлтэс		0	1	5	1	2	1	2	30	0	0
III хэлтэс		0	1	7	2	3	3	0	12	0	1
Сонгинохайрхан	2021	1	30	64	2	6	17	10	109	4	0
I хэлтэс		1	12	33	1	6	15	1	72	1	0
II хэлтэс		0	14	16	1	0	2	7	25	1	0
III хэлтэс		0	4	15	0	0	0	2	12	2	0
2021/2020		100.0	5дах	2.5 дах	40.0	85.7	130.8	2.5 дах	104.8	2.0 дах	0.0

2021 онд нийслэл хотод гарсан гарсан гэмт хэргийн 2118(12.8%) нь согтуугаар үйлдэгдсэн, 490(3.0%) хүүхэд оролцсон, 2443(14.8%) эмэгтэй хүн оролцсон, 852(5.1%) нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн байна.Тайлант онд согтуугаар үйлдэгдсэн хэрэг 684(32.3%) Баянзүрх дүүрэгт, 181(8.5%) Баянгол дүүрэгт, 152(7.2%) Сүхбаатар дүүрэгт, 360(17.0%) Сонгинохайрхан дүүрэгт, 255(12.0%) Хан уул дүүрэгт, 275(13.0%) Чингэлтэй дүүрэгт, 84(3.9%) Багануур дүүрэгт, 10(0.5%) Багахангай дүүрэгт, 117(5.5%) Налайх дүүрэгт тус тус гарсан байна.

Дүрслэл 2. Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал, дүүргээр




2021 онд нийслэл хотод өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 9785 гарсны 1937(19.8%) нь Баянгол, 2408(24.6%) нь Баянзүрх, 1428(14.6%) нь Сүхбаатар, 1479(15.1%) нь Сонгинохайрхан, 1279(13.1%) нь Хан-уул, 1119(11.4%) нь Чингэлтэй, 55(0.6%) нь Багануур, 5(0.1%) нь Багахангай, 75(0.8%) нь Налайх дүүрэгт тус тус гарсан байна. Тайлант онд нийслэл хотод гарсан нийт өмчлөх эрхийн эсрэг хэргийн хэргийн 3283(33.6%) нь хулгайлах гэмт хэрэг, 305(3.1%) нь дээрэм, 5240(53.6%) нь залилах гэмт хэрэг байна.

Хүснэгт 4. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн тоо

Үзүүлэлт	Сонгинохайрхан	I хэлтэс	II хэлтэс	III хэлтэс	Сонгинохайрхан	I хэлтэс	II хэлтэс	III хэлтэс	2021/2020
Өмчлөх эрхийн эсрэг	1257	611	323	323	1479	735	396	348	117.7
Хулгайлах	729	382	186	161	681	335	197	149	93.4
Хувийн өмч хулгайлах	689	357	181	15	613	302	185	126	89.0
Автотээврийн хэрэгслэл хулгайлах	23	18	2	3	18	12	2	4	78.3
Халаасны хулгай	12	4	3	5	43	15	9	19	3.6 дах
Дээрэмдэх	77	29	16	32	93	37	21	35	120.8
Залилах	322	132	86	104	526	272	129	125	163.4
Хөрөнгө завших	27	11	6	10	36	14	9	13	133.3
Эд хөрөнгө устгах, гэмтээх	23	12	8	3	32	10	16	6	139.1
Мал хулгайлах	27	27	0	0	23	22	1	0	85.2
Авто тээврийн хэрэгслэл зөвшөөрөлгүй авч явах	11	7	4	0	13	8	3	2	118.2

2021 онд Өмчлөх эрхийн эсрэг хэрэг 1479(50.9%) гарсан нь өмнөх оноос 222(17.7%) хэргээр өссөн байна. Тайлант хугацаанд Сонгинохайрхан дүүрэгт гарсан нийт хэргийн 50.9 хувь нь өмчлөх эрхийн эсрэг хэрэг байна. Нийт өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 681(46.0%) нь хулгайлах гэмт хэрэг, 93(6.3%) нь дээрэмдэх, 526(35.6%) нь залилах, 36(2.4%) нь хөрөнгө завших, 32(2.2%) нь эд хөрөнгө устгах гэмтээх, 23(1.6%) нь мал хулгайлах, 13(0.9%) нь авто тээврийн хэрэгслэл зөвшөөрөлгүй авч явах хэрэг байна. Хулгайлах гэмт хэргийн 613(90.0%) нь хувийн өмч хулгайлах, 18(2.6%) нь автотээврийн хэрэгслэл хулгайлах, 43(6.3%) нь халаасны хулгайн гэмт хэрэг байна. Хулгайлах гэмт хэрэг өнгөрсөн оноос 48(6.6%) хэргээр буурсан байна. Харин залилах гэмт хэрэг 204(63.4%) хэргээр, авто тээврийн хэрэгслэл зөвшөөрөлгүй авч явах хэрэг 2(18.2%) хэргээр, дээрэм 16(20.8%) хэргээр, хөрөнгө завших 9(33.3%) хэргээр, халаасны хулгай 3.6 дахин тус тус нэмэгдсэн байна. Харин мал хулгайлах гэмт хэрэг 5(14.8%) хэргээр, хувийн өмч хулгайлах гэмт хэрэг 76(11.0%) хэргээр, авто тээврийн хэрэгслэл хулгайлах гэмт хэрэг 5(21.7%) хэргээр тус тус буурсан байна.

Дүрслэл 3. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, дүүргээр



Тайлант хугацаанд гарсан өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 735(49.7%) нь цагдаагийн нэгдүгээр хэлтэст,396(26.8%) нь цагдаагийн хоёрдугаар хэлтэст,348(23.5%) нь цагдаагийн гуравдугаар хэлтэст тус тус харьяалагдаж байна.

2021 онд Сонгинохайрхан дүүрэгт гарсан нийт хэргийн 453(15.6%) нь Даваа гарагт, 453(15.6%) нь Мягмар гарагт, 437(15.1%) нь Лхагва гарагт, 448(15.4%) нь Пүрэв гарагт, 456(15.7%) нь Баасан гарагт, 342(11.8%) нь Бямба гарагт, 314(10.8%) нь Ням гарагт тус тус гарсан байна. Тайлант онд өдөрт гардаг хэргийн тоо ойролцоо байсан бөгөөд нэг өдөрт дунджаар 415 хэрэг гарсан байна. Баасан гарагт хамгийн их хэрэг гарсан бөгөөд Бямба,Ням гарагт хамгийн бага хэрэг гарчээ.

Хүснэгт 5. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, хэрэг үйлдэгдсэн гарагаар

Үзүүлэлт	Он	Гараг						
		Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням
Сонгинохайрхан	2020	362	344	350	343	337	304	297
I хэлтэс		185	178	174	166	174	125	142
II хэлтэс		96	75	90	105	88	90	70
III хэлтэс		81	91	86	72	75	89	85
Сонгинохайрхан	2021	453	453	437	448	456	342	314
I хэлтэс		242	229	218	239	235	163	143
II хэлтэс		112	130	109	113	129	107	110
III хэлтэс		99	94	110	96	92	72	61
2021/2020		125.1	131.7	124.9	130.6	135.3	112.5	105.7


Тайлант хугацаанд гарсан гэмт хэргийн 870(29.9%) нь 06-14 цагийн хооронд,880(30.3%) нь 14-19 цагийн хооронд, 451(15.5%)нь 19-22 цагийн хооронд, 702(24.2%) нь 22-06 цагийн хооронд тус тус гарсан байна. Тайлант хугацаанд гарсан хэргийн байдлаас харахад 14-19 цагийн хооронд хамгийн их хэрэг гарсан бол 19-22 цагийн хооронд хамгийн бага хэрэг гарсан байна. 2021 онд Цагдаагийн нэгдүгээр хэлтэст 06-14 цагийн хооронд хамгийн их буюу 482 хэрэг гарсан бол цагдаагийн хоёрдугаар хэлтэст хамгийн их хэрэг 14-19 цагийн хооронд 258 хэрэг, цагдаагийн гуравдугаар хэлтэст 14-19 цагийн хооронд хамгийн их хэрэг 219 хэрэг тус тус гарсан байна.

Хүснэгт 6. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, гэмт хэрэг үйлдэгдсэн цагаар

Үзүүлэлт	Он	Цаг			
		06-14	14-19	19-22	22-06
Сонгинохайрхан	2020	636	719	363	619
I хэлтэс		332	326	159	327
II хэлтэс		166	211	100	137
III хэлтэс		138	182	104	155
Сонгинохайрхан	2021	870	880	451	702
I хэлтэс		482	403	233	351
II хэлтэс		207	258	140	205
III хэлтэс		181	219	78	146
2021/2020		136.8	122.4	124.2	113.4

2021 онд нийслэл хотод гарсан гэмт хэргийн байршилийн хувьд гэр орон сууцанд Баянзүрх дүүрэгт хамгийн их буюу 1647 хэрэг, Сүхбаатар дүүрэгт 657 хэрэг гарсан байна. Олон нийтийн газарт гарсан хэргийн хамгийн их нь Баянгол дүүрэгт 435 байгаа бол Хан уул дүүрэгт 151 хэрэг гарсан байна. Гудаамж талбайд гарсан хэргийн хамгийн их нь Баянзүрх дүүрэгт 1018 гарсан бөгөөд Чингэлтэй дүүрэгт 401 хэрэг гарсан байна. Нийт тээвэрт гарсан хэргийн хамгийн их нь Сонгинохайрхан дүүрэгт байгаа бол Баянгол, Чингэлтэй дүүрэгт 9 хэрэг ногдож байна.

Дүрслэл 4. Хэрэг үйлдэгдсэн газар, дүүргээр



Сонгинохайрхан дүүрэгт 2021 онд гарсан нийт хэргийн 1339(46.1%) нь гэр орон сууцанд гарсан хэрэг бөгөөд өнгөрсөн оноос 327(32.3%) хэргээр өссөн байна. Тайлант онд нийт гэр орон сууцанд гарсан хэргийн 514(38.4%) нь гэрт, 245(18.3%) нь орон сууцны байранд, 390(29.1%) нь хувийн байшинд, 53(3.9%) нь зуслангийн байшинд, 60(4.5%) нь нийтийн байранд, 7(0.5%) нь гаражид тус тус гарсан байна. Тайланд онд гэрт гарсан хэрэг 13,0 хувиар, орон сууцанд гарсан хэрэг 53.1 хувиар, хувийн байшинд гарсан хэрэг 48.9 хувиар, зуслангийн байшинд гарсан гарсан хэрэг 65.6 хувиар, нийтийн байранд гарсан хэрэг 62.2 хувиар тус тус өссөн байна.

Тайлант онд нийт гэр, орон сууцанд гарсан хэргийн 628(46.9%) нь цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 456(34.1%) нь цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 255(19.0%) нь цагдаагийн гуравдугаар хэлтэст тус тус бүртгэгдсэн байна.

Хүснэгт 7. Гэр, орон сууцанд үйлдэгдсэн хэрэг

Үзүүлэлт	Он	Гэр, орон сууц						
			гэр	орон сууцны байр	хувийн байшин	зуслангийн байшин	нийтийн байр	гараж
Сонгинохайрхан	2020	1012	455	160	262	32	37	7
I хэлтэс		466	210	52	135	22	9	6
II хэлтэс		325	179	31	90	10	8	0
III хэлтэс		221	66	77	37	0	20	1
Сонгинохайрхан	2021	1339	514	245	390	53	60	7
I хэлтэс		628	265	91	189	29	21	1
II хэлтэс		456	197	41	153	23	17	5
III хэлтэс		255	52	113	48	1	22	1
2021/2020		132.3	113.0	153.1	148.9	165.6	162.2	100.0

Тайлант онд гудамж тайлбайд 639 хэрэг гарсан нь Сонгинохайрхан дүүрэгт гарсан нийт хэргийн 22.0 хувь болж байна. Тайлант хугацаанд гудамж тайлбайд гарсан нийт хэргийн 270(42.3%) нь гэр хорооллын гудамжинд, 134(21.0%) нь орон сууцны гудамжинд, 60(9.4%) нь ил зогсоол дээр, 71(11.1%) нь автобусын буудал дээр тус тус гарсан байна. Тайлант хугацаанд гудамж талбайд гарсан хэрэг өмнөх оны мөн үеэс 218(51.8%) хэргээр нэмэгдсэн байна. Төйлант онд гэр хорооллын гудамж талбайд гарсан хэрэг өмнөх оноос 117(51.8%) хэргээр, орон сууцны хорооллын гудамж талбайд гарсан хэрэг 28(51.8%) хэргээр, ил зогсоол дээр гарсан хэрэг 15(51.8%) хэргээр, автобусны буудал дээр гарсан хэрэг 23(51.8%) хэргээр тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 8. Гудамж талбайд үйлдэгдсэн хэрэг

Үзүүлэлт	Он	Гудамж, талбай				
			гэр хорооллын гудамж	орон сууцны хорооллын гудамж	ил зогсоол	автобусны буудал
Сонгинохайрхан	2020	421	153	106	45	48
I хэлтэс		116	43	21	13	16
II хэлтэс		145	78	9	10	14
III хэлтэс		160	32	76	22	18
Сонгинохайрхан	2021	639	270	134	60	71
I хэлтэс		288	121	57	22	34
II хэлтэс		173	109	15	6	17
III хэлтэс		178	40	62	32	20
2021/2020		151.8	176.5	126.4	133.3	147.9

Тайлант онд олон нийтийн газарт 166 хэрэг гарсан дүүрэгт гарсан нийт хэргийн 5.7 хувийг эзэлж байгаа бөгөөд олон нийтийн газарт гарсан нийт хэргийн 32(19.3%) нь дэлгүүрт, 20(12.0%) нь зочид буудалд, 14(8.4%) нь бааранд, 3(1.8%) нь ресторан зоогийн газарт, 23(13.9%) нь автовокзал дээр, 7(4.2%) нь цайны газарт тус тус гарсан байна. Тайлант хугацаанд олон нийтийн газарт гарсан хэрэг өмнөх оны мөн үеэс 6(3.8%) хэргээр өссөн байна. Тайлант онд дэлгүүрт гарсан хэрэг 33.3 хувиар, зочид буудал гарсан хэрэг 17.6 хувиар, авто вокзал дээр гарсан хэрэг 2.3 дахин өссөн бол бааранд гарсан хэрэг 48.1 хувиар, ресторон зоогийн газарт гарсан хэрэг 72.7 хувиар тус тус буурсан байна. Эдгээр үзүүлэлтийн өөрчлөлт нь цар тахалын үеийн арга хэмжээний үр дүнтэй холбоотой гэж үзэж байна.

Хүснэгт 9. Олон нийтийн газарт үйлдэгдсэн хэрэг

Үзүүлэлт	Он	Олон нийтийн газар						
		дэлгүүр	зочид буудал	баар	ресторан, зоогийн газар	авто вокзал	цайны газар	
Сонгинохайрхан	2020	160	24	17	27	11	10	7
I хэлтэс		56	7	6	4	4	1	3
II хэлтэс		26	7	2	2	0	1	0
III хэлтэс		78	10	9	21	7	8	4
Сонгинохайрхан	2021	166	32	20	14	3	23	7
I хэлтэс		41	7	7	1	1	0	0
II хэлтэс		32	9	4	4	0	0	1
III хэлтэс		93	16	9	9	2	23	6
2021/2020		103.8	133.3	117.6	51.9	27.3	2.3 дах	100.0

Тайлант онд нийтийн тээвэрт 27 хэрэг гарсан нь өмнөх оноос 10(27.0%) хэргээр буурсан байна. Тайлан хугацаанд нийтийн тээвэрт гарсан гэмт хэргийн 17(62.9%) нь том оврын автобусанд, 3(5.4%) нь дунд оврын автобусанд, 5(18.5%) нь таксид тус тус гарсан байна. Тайлант онд том оврын автобусанд гарсан хэрэг 54.5 хувиар, дунд оврын автобусанд гарсан хэрэг 50.0 хувиар өнгөрсөн оноос өссөн бөгөөд микро автобусанд хэрэг гараагүй байна. 2020 онд таксид гарсан хэрэг өнгөрсөн оноос 11(68.7%) хэргээр буурсан байна.

Хүснэгт 10. Нийтийн тээвэрт үйлдэгдсэн хэрэг

Үзүүлэлт	Он	нийтийн тээвэр	нийтийн тээвэр			
			том оврын автобус	дунд оврын автобус	микро	такси
Сонгинохайрхан	2020	37	11	2	1	16
I хэлтэс		5	0	1	1	2
II хэлтэс		1	1	0	0	0
III хэлтэс		31	10	1	0	14
Сонгинохайрхан	2021	27	17	3	0	5
I хэлтэс		8	5	1	0	1
II хэлтэс		2	1	0	0	0
III хэлтэс		17	11	2	0	4
2021/2020		73.0	154.5	150.0	0.0	31.3

Тайлант онд нийтийн тээвэрт гарсан хэргийн 8(29.6%) цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 2(7.4%) цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 17(63.0%) цагдаагийн гуравдугаар хэлтэст тус тус бүртгэгдсэн байна.

2021 онд Сонгинохайрхан дүүрэгт гарсан нийт хэргийн 179(6.2%) нь аж ахуйн нэгжид, 10(0.3%) нь төрийн байгууллагад, 9(0.3%) нь төрийн бус байгууллагад, 118(4.1%) нь авто зам дээр, 416(14.3%) бусад газарт тус тус гарсан байна. Тайлант хугацаанд аж ахуйн нэгжид гарсан хэргийн 93(52.0%) нь цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 37(20.7%) нь цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 49(27.4%) нь цагдаагийн гуравдугаар хэлтэст байрлах аж ахуйн нэгжид тус тус гарсан байна.

Хүснэгт 11. Хэрэг үйлдэгдсэн газар, өмчийн хэлбэрээр

Үзүүлэлт	Он	Төрийн байгууллага	Төрийн бус байгууллага	Аж ахуйн нэгж	Авто зам	Бусад
Сонгинохайрхан	2020	12	12	174	104	405
I хэлтэс		9	8	71	63	350
II хэлтэс		0	4	35	29	49
III хэлтэс		3	0	68	12	6
Сонгинохайрхан	2021	10	9	179	118	416
I хэлтэс		5	5	93	77	324
II хэлтэс		2	3	37	27	78
III хэлтэс		3	1	49	14	14
2021/2020		83.3	75.0	102.9	113.5	102.7

2021 онд хэрэг үйлдсэн хүний тоо 1679 байсан нь өмнөх оноос 206(14.0%) хүнээр нэмэгдсэн байна. Тайлант хугацаанд хэрэг үйлдсэн нийт хүний 34(2.0%) нь төрийн албан хаагч, 97(5.8%) нь хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч, 29(1.7%) нь төрийн бус байгууллагад ажиллагч, 462 (27.5%) нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 10(0.6%) нь малчин, 20(1.2%) нь оюутан, 41(2.4%) нь сурагч, 14(0.8%) нь сургууль завсардсан буюу тэнэмэл хүүхэд, 9(0.5%) нь хоригдол, 1(0.1%) нь хугацаат цэргийн албан хаагч, 962(57.3%) нь ажилгүй иргэн байна. Тайлант онд хэрэг үйлдсэн ажилгүй иргэн 962 байсан нь өмнөх оноос 183(14.0%) аар өссөн байна. Тайлант онд хэрэг үйлдсэн төрийн албан хаагч 6.3 хувиар, төрийн бус байгууллагын ажилтан 61.1 хувиар, хувиараа хөдөлмөр эрхлэгч 14.1 хувиар, хоригдол 80.0 хувиар, ажилгүй иргэн 23.5 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Тайлант хугацаанд хэрэг үйлдсэн хүний 811(48.3%) нь цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 492(29.3%) нь цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 376(22.4%) нь цагдаагийн гуравдугаар хэлтэст бүртгэлтэй байна.

Хүснэгт 12. Хэрэг үйлдэгсэд, нийгмийн байдлаар

Үзүүлэлт	Сонгинохайрхан	I хэлтэс	II хэлтэс	III хэлтэс	Сонгинохайрхан	I хэлтэс	II хэлтэс	III хэлтэс	2021/2020
Он	2020				2021				
Төрийн албан хаагч	32	21	4	7	34	16	6	12	106.3
Хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч	100	28	13	59	97	54	10	33	97.0
Төрийн бус байгууллагын ажилтан	18	7	4	7	29	5	8	16	161.1
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	405	250	78	77	462	268	111	83	114.1
Малчин	30	27	0	3	10	8	1	1	33.3
Оюутан	23	7	5	11	20	9	6	5	87.0
Сурагч	48	29	10	9	41	18	12	11	85.4
Сургууль завсардсан хүүхэд, тэнэмэл хүүхэд	32	15	7	10	14	1	3	10	43.8
Хоригдол	5	0	5	0	9	3	6	0	180.0
Хугацаат цэргийн алба хаагч	1	0	0	1	1	1	0	0	100.0
Ажилгүй	779	322	251	206	962	428	329	205	123.5
Нийт	1473	706	377	390	1679	811	492	376	114.0

Тайлант онд хэрэг үйлдсэн нийт хүний 268(16.0%) нь эмэгтэй, 34(2.0%) нь 15 хүртэлх насны, 44(2.6%) нь 16-17 настай, 372(22.2%) нь 18-24 настай, 255(15.2%) нь 25-29 настай, 323(19.2%) нь 30-34 настай, 213(12.7%) нь 35-39 настай, 157(9.4%) нь 40-44 настай, 110(6.6%) нь 45-49 настай, 58(3.5%) нь 50-54 настай, 49(2.9%) нь 55-59 настай, 27(1.6%) нь 60 аас дээш настай байна. Тайлант онд хэрэг үйлдсэн эмэгтэйчүүдийн тоо өмнөх оноос 2(3.8%) хүнээр, 60 болон түүнээс дээш насны хүн 10(19.0%) ээр нэмэгдсэн бол 15 хүртэлх насны хүүхдийн тоо 30(1.6%) ээр буурсан байна.

Хүснэгт 13. Хэрэг үйлдэгсэд, насны бүлгээр

Үзүүлэлт		Сонгинохайрхан	I хэлтэс	II хэлтэс	III хэлтэс	Сонгинохайрхан	I хэлтэс	II хэлтэс	III хэлтэс	2021/2020
Он		2020			2021					
Бүх хүн		1473	706	377	390	1679	811	492	376	114.0
Эмэгтэй		249	99	76	74	268	127	90	51	107.6
насны бүлэг	15 хүртэлх	64	32	18	14	34	17	8	9	53.1
	16-17	69	33	22	14	44	17	14	12	63.8
	18-24	317	139	93	85	372	170	115	87	117.4
	25-29	298	138	68	92	255	118	75	62	85.6
	30-34	229	109	61	59	323	175	84	64	141.0
	35-39	171	79	40	52	213	99	59	55	124.6
	40-44	129	70	29	30	157	74	50	33	121.7
	45-49	91	47	23	21	110	57	30	23	120.9
	50-54	58	34	12	12	58	34	12	12	100.0
	55-59	30	16	7	7	49	28	11	10	163.3
60+	17	9	4	4	27	8	11	8	158.8	

Тайлант хугацаанд хэрэг үйлдсэн хүний 26(1.5%) нь боловсролгүй, 88(5.2%) нь бага боловсролтой, 281(16.7%) нь суурь боловсролтой, 1034(61.6%) нь бүрэн дунд боловсролтой, 79(4.7%) нь тусгай мэргэжилийн дунд боловсролтой, 171(10.2%) нь дээд боловсролтой байна.

Хүснэгт 14. Хэрэг үйлдэгсэд, боловсролын түвшингээр

Үзүүлэлт	Он	Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Тусгай мэргэжлийн дунд	Дээд
Сонгинохайрхан	2020	28	136	358	739	43	169
I хэлтэс		7	70	201	351	18	59
II хэлтэс		11	27	91	206	5	37
III хэлтэс		10	39	66	182	20	73
Сонгинохайрхан	2021	26	88	281	1034	79	171
I хэлтэс		12	29	143	519	39	69
II хэлтэс		6	43	79	305	18	41
III хэлтэс		8	16	59	210	22	61
2021/2020		92.9	64.7	78.5	139.9	183.7	101.2

Тайлант хугацаанд гарсан гэмт хэргийн улмаас 11055.0 сая төгрөгийн хохирол учирсан нь өнгөрсөн оноос 652.0(5.6%) сая төгрөгөөр буурсан байна. Хөнгөн гэмт хэргийн улмаас учирсан хохирол 9163.4 сая төгрөг байгаа нь өнгөрсөн оноос 188.6(2.1%) сая төгрөгөөр нэмэгдэж, хүнд гэмт хэргийн улмаас учирсан хохирол 840.2(30.8%) сая төгрөгөөр хасагдсан байна. Тайлант онд гарсан хэргийн байдлыг харахад гэмт хэргийн гаралтын тоо өмнөх оноос өссөн боловч нийт дүнгээр учирсан хохирлын хэмжээ хасагдсан байна.

Хүснэгт 15. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, сая төгрөгөөр

Үзүүлэлт	Он	Гэмт хэргийн улмаас учирсан хохирол	Ангилал		Өмчийн хэлбэр		
			хөнгөн	хүнд	төрийн	орон нутгийн	хувийн
Сонгинохайрхан	2020	11707	8974.8	2731.7	628.2	4.5	11074
I хэлтэс		6646.7	5072.5	1574.2	603	4.5	6039.3
II хэлтэс		2886.8	2541.1	345.6	1	0	2885.8
III хэлтэс		2173	1361.2	811.9	24.2	0	2148.8
Сонгинохайрхан	2021	11055	9163.4	1891.6	8.8	4.4	11042
I хэлтэс		8277.2	7055.3	1221.9	8.8	3.8	8264.5
II хэлтэс		1341.3	1045.6	295.8	0	0.5	1340.8
III хэлтэс		1436.6	1062.6	374	0	0	1436.6
2021/2020		94.4	102.1	69.2	1.4	97.8	99.7

2021 онд гэмт хэргийн улмаас хохирсон иргэн нийт 2861 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 547 хүнээр нэмэгдсэн байна. Гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн 1321(46.2%) нь эмэгтэй, 73(2.6%) нь 14 хүртэлх насны хүүхэд, 133(4.6%) нь 60 ба түүнээс дээш насны хүн ам байна. Тайлант онд гэмт хэргийн улмаас хохирсон эмэгтэйчүүдийн тоо өмнөх оноос 261(30.8%) хүнээр, 14 хүртэлх насны хүүхэд 16(28.1%) -аар, 14-17 настай хүний тоо 39(51.3%)-өөр, 18-24 насны хүний тоо 65(23.6%)-аар, 25-29 насны хүний тоо 56(17.1%) аар, 30-34 насны хүний тоо 71(16.1%) аар, 35-39 насны хүн 79(23.9%) хүнээр, 40-44 насны хүн ам 117(49.0%) аар, 45-49 насны хүн 41 (20.5%) ээр, 50-54 насны хүн ам 38(25.9%)-аар тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 16.Хохирогчид, насны бүлгээр

Үзүүлэлт	Сонгинохайрхан	I хэлтэс	II хэлтэс	III хэлтэс	Сонгинохайрхан	I хэлтэс	II хэлтэс	III хэлтэс	2021/2020	
Он	2020				2021					
Бүх хүн	2314	1216	520	578	2861	1535	710	616	123.6	
Эмэгтэй	1060	534	269	257	1321	681	357	283	124.6	
насны бүлэг	14 хүртэлх	57	37	12	8	73	34	22	17	128.1
	14-17	76	43	17	16	115	56	28	31	151.3
	18-24	276	130	69	77	341	170	86	85	123.6
	25-29	327	149	80	98	383	211	85	87	117.1
	30-34	442	227	92	123	513	264	138	111	116.1
	35-39	330	190	58	82	409	229	86	94	123.9
	40-44	239	127	58	54	356	194	99	63	149.0
	45-49	200	102	51	47	241	130	64	47	120.5
	50-54	147	80	36	31	185	101	52	32	125.9
	55-59	94	64	16	14	112	70	23	19	119.1
60+	126	67	31	28	133	76	27	30	105.6	

Тайлант онд гэмт хэргийн улмаас 1030 хүн гэмтсэн бөгөөд 843(81.8%) хүн хөнгөн, 118(18.2%) хүн хүндэвтэр, 69(6.7%) хүн хүнд гэмтэл авсан байна. Гэмтсэн хүний тоо өмнөх оноос 189 (22.5%) хүнээр нэмэгдсэн байна. Нийт гэмтсэн хүний 403(39.1%) эмэгтэй, 37(3.6%) нь 14 хүртэлх насны хүүхэд байна.

Хүснэгт 17. Гэмт хэргийн улмаас гэмтсэн хүн

Үзүүлэлт	Он	Гэмтсэн хүн	Гэмтлийн зэрэг			Нийт гэмтсэн хүнээс			
			хөнгөн	хүндэвтэр	хүнд	эмэгтэй	7 хүртэлх	8--13	14-17
Сонгинохайрхан	2020	841	676	109	56	355	5	21	41
I хэлтэс		460	365	64	31	186	4	12	26
II хэлтэс		160	113	29	18	73	1	5	5
III хэлтэс		221	198	16	7	96	0	4	10
Сонгинохайрхан	2021	1030	843	118	69	403	7	30	42
I хэлтэс		562	451	76	35	227	2	13	21
II хэлтэс		237	199	20	18	98	4	11	11
III хэлтэс		231	193	22	16	78	1	6	10
2020/2019		122.5	124.7	108.3	123.2	113.5	140.0	142.9	102.4

Тайлант онд 62018 зөрчил бүртгэгдсэн нь өнгөрсөн оноос 42200 зөрчлөөр нэмэгдсэн байна. Нийт бүртгэгдсэн зөрчлийн 43972(70.9%) нь ердийн журмаар шийдвэрлэсэн, 18046(29.1%) нь хялбаршуулсан журмаар шалгасан зөрчил байна.

Хүснэгт 18. Бүртгэгдсэн зөрчлийн тоо

Үзүүлэлт	Он	Нийт зөрчил	Нийт зөрчил	
			ердийн журмаар шийдвэрлэсэн	хялбаршуулсан журмаар шалгасан
Сонгинохайрхан	2020	19818	12075	7743
I хэлтэс		8313	5277	3036
II хэлтэс		5236	2671	2565
III хэлтэс		6269	4127	2142
ЗЦ-ийн хэлтэс		0	0	0
Сонгинохайрхан	2021	62018	43972	18046
I хэлтэс		8335	3225	5110
II хэлтэс		7020	2029	4988
III хэлтэс		12967	10195	2772
ЗЦ-ийн хэлтэс		33696	28520	5176
2021/2020		312.9	x	x

2021 онд Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн нийт зөрчлийн 8335(40.4%) нь цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 7020(22.2%) нь цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 12967(20.9%) нь цагдаагийн гуравдугаар хэлтэст, 33696(54.3%) замын цагдаагийн хэлтэст тус тус бүртгэгдсэн байна.

Сонгинохайрхан дүүргийн
Засаг даргын дэргэдэх
Статистикийн хэлтэст эмхэтгэв.